| 8.1.3 | Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуулын ажлын жилийн төлөвлөгөө, төсвийг батлах, түүний гүйцэтгэлд хяналт тавих | - | Эрлийн болон хайгуулын ажлын төлөвлөгөөг хүлээн авч хянан зохих засвар өөрчлөлтийг хийлгэн заавар шаардлагад нийцүүлэн баталсан байна. | Эрэл, хайгуулын ажлын төлөвлөгөө баталсан. | 100% | Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл: Зууны нээлт ХХК 2022.12.08-ны өдөр, Энержи ресурс ХХК 2022.12.14-ний өдөр, Жейд Газ Монгол ХХК 2023.01.06, 2023.01.23-ны өдөр, Ууганбулаг ХХК 2023.01.24-ний өдөр, Жаргал Инвестмент ХХК 2023.05.24-ний өдөр, Баруун наран газ ХХК 2023.07.07-ны өдөр, Коммон макс ХХК 2023.07.17-ны өдөр, Си Эйч Би Ти Ти ХХК 2023.10.17-ны өдөр төлөвлөгөө, төсвийг тус тус ирүүлсэн ба тухай бүр хүлээн авч, мэргэжилтнүүдийн саналыг авч нэгтгэн, баталсан. Газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуул: Гэрээлэгч Тэлмэн Ресурс ХХК 2023.01.20, Жи Өү Эйч ХХК 2023.01.31, Түмэн ойл ХХК 2023.02.15, Монголын Алт /МАК/ ХХК 2023.03.21, Капкорп Монголиа ХХК 2023.01.31, Смарт ойл Монголиа ХХК 2023.03.01, Метан газ ресурс ХХК 2023.01.31, Тахь ресурс ХХК 2023.01.20-ны өдөр Онги V, 2023.03.01-ний өдөр Богд IV, 2023.03.20-ны өдөр Т I, Шунхлай Энержи ХХК 2023.03.31, Макс ойл ХХК 2023.05.16-ны өдрүүдэд нийт 10 компанийн 12 төлөвлөгөө, төсвийг тус тус батлуулсан. Мөн “Тахь ресурс” ХХК Онги V талбайд нэмэлт хайгуулын ажлын төлөвлөгөө ирүүлж, 2023.04.10-ны өдөр баталсан. Нүүрсний метан хийн хайгуулын 6 талбайд, газрын тосны хайгуулын 3 талбайд хээрийн ажил хийгдэж, өдөр тутмын мэдээг хүлээн хүлээн авч, хяналт тавьж ажилласан. | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 8.1.4 | Эрэл, хайгуулын талбайд гүйцэтгэсэн газрын тос, уламжлалт бус газрын тосны геологи, геофизик, гидрогеологи, геохими, өрөмдлөг, хайгуул, ашиглалттай холбогдсон үйл ажиллагааны анхдагч мэдээлэл, тайлан, материалыг хүлээн авах, хянах, мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх, хүлээн авах. | - | Тайлан, материалыг хүлээн авч, шаардлагатай тайлан материалыг мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн байна. | Тайлан материалыг мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн. | 100% | Гэрээлэгчдийн хайгуулын ажлын 56 тайлан материал ирүүлснийг хянаж 48 тайланг хүлээн авч, 8 тайлан хянагдаж байна. Газрын тосны салбарын мэргэжлийн зөвлөлийн хурлаар дараах асуудлыг хэлэлцэж, шийдвэрлэсэн. 1. Газрын тосны хайгуулын үйл ажиллагаанд мөрдөх жишиг үнийн тухай, 2. Нялга XVI, Хөх нуур XVIII, Сүхбаатар XXVII талбайн багц материалын үнийг шинэчлэх эсэх, 3. БХГ-т талбайд өмнөх гэрээлэгчийн хийсэн хайгуулын ажлын анхдагч мэдээ, мэдээлэл тайланг үнэлэх эсэх, 4. Метан газ ресурс ХХК-ийн Тавантолгой XXXIII талбайд өрөмдсөн RedLake#05, RedLake#07, цооногийг нээлттэй цооногоор бүртгэх, 5. Жи Өү Эйч ХХК, Тахь Ресурс ХХК-уудаас ирүүлсэн нүүрсний давхаргын метан хийн эрлийн гэрээ байгуулах хүсэлтийн талаарх танилцуулга. | 90% |
| 8.1.5 | Эрлийн гэрээ болон Бүтээгдэхүүн хуваах гэрээний хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих, батлагдсан төлөвлөгөөт ажлын гүйцэтгэлд газар дээр нь хяналт тавих | - | Хяналт тавин мэргэжил аргазүйн зөвлөмж өгөх, эрэл хайгуулын ажлыг эрчимжүүлсэн байна. | Хяналт тавьж ажилласан. | 100% | Метан газ ресур ХХК 13, Тахь ресурс ХХК 9, Жи Өү Эйч ХХК 7, Тэлмэн ресурс ХХК 3, нийт нүүрсний давхаргын метан хийн хайгуул, туршилтын 32 цооног өрөмдөж, Метан газ ресур ХХК 105 , Тэлмэн ресурс ХХК 50, Тахь ресурс ХХК 105 тууш.км, нийт 260 тууш,км 2 хэмжээст чичирхийллийн судалгааны ажил хийж, өдөр тутмын мэдээллийг цахимаар хүлээн авч, хянаж ажилласан. Монголын алт /МАК/ ХХК, Капкорп Монголиа ХХК тус бүр 1, нийт газрын тосны хайгуулын хайгуулын 2 цооног өрөмдөж, Смарт ойл Монголиа 547,5 км.кв 3 хэмжээст чичирхийллийн судалгааны ажил хийж өдөр тутмын мэдээллийг цахимаар хүлээн авч, хянаж ажилласан. Хайгуулын ажил эхлэх, явцын хяналт тавихаар Номгон IX, Төхөм X /хойд/, Эргэл XII, Тавантолгой XXXIII, Гурвантэс XXXV, Т 1, Богд IV, Онги V талбайд 5 мэргэжилтэн 87 хоног ажиллаж хяналт тавьж ажилласан. | 90% |
| 8.1.6 | Гэрээлэгч нартай жилийн ажлын уулзалтыг зохион байгуулж 2022 онд хийгдсэн хайгуулын ажлын үр дүн, | - | Жилийн ажлын уулзалтыг зохион | Бүтээгдэхүүн хуваах гэрээний хэрэгжилти | 100% | Агентлагийн даргын 2023.01.16-ны өдрийн А/11 дүгээр Жилийн ажлын уулзалт зохион байгуулах тухай тушаалын дагуу 2023.01.17-ны өдрөөс 2023.03.28-ны өдрийн хооронд газрын тос, уламжлалт бус газрын | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 2023 онд хийгдэх хайгуулын ажлын төлөвлөгөө төслийн талаар хэлэлцэж тулгамдаж буй асуудал дээр харилцан санал солилцон, бүтээгдэхүүн хуваах гэрээний тухайн жилийн хэрэгжилтийг дүгнэх | | байгуулсан байна. Гэрээний хэрэгжилтийг дүгнэсэн байна. | йг дүгнэсэн. | | тосны хайгуулын 14 талбайн 12 гэрээлэгчтэй жилийн ажлын уулзалтыг зохион байгуулж, БХГ-ний 2022 оны хэрэгжилт, төлөвлөгөөний гүйцэтгэл, 2023 оны төлөвлөгөө, төсвийг хэлэлцсэн. Метан газ ресурс ХХК /Тавантолгой XXXIII/-тай 2023.01.17, Тэлмэн ресурс ХХК /Гурвантэс XXXV/-тай 2023.01.18, Жи Өү Эйч ХХК /Номгон IX/-тай 2023.01.20, Капкорп Монголиа ХХК /Онги V/-тай 2023.01.25, Түмэн ойл ХХК /Баянтүмэн XVII/-тай 2023.01.31, Петровис ресурс ХХК /Богд-IV, Онги-V, Т1/-тай 2023.02.15, Макс ойл ХХК /Арбулаг XXIX/-тай 2023.02.16, Смарт ойл Монголиа ХХК /Эргэл XII/-тай 2023.02.28, Монголын алт (МАК) ХХК /Төхөм X урд/-тай 2023.03.15, Зон хэн юу тиан ХХК /Галба XI/-тай 2023.03.16, Чайна голден сий петролиум эксплорэйшн корпорэйшн ХХК /Тариач XV/-тай 2023.03.23, Шунхлай энержи ХХК /Сулинхээр XXIII/-тай 2023.03.28-ны өдөр тус тус жилийн ажлын уулзалтуудыг зохион байгуулсан. Увс I талбайн БХГ-ний хугацаа 2023 оны 06 дугаар сард дуусгавар болсон тул БХГ-г дүгнэж, УУХҮЯ-нд 2023.10.16-ны өдрийн 1/4866 дугаар албан бичгээр дүгнэлтийг хүргүүлсэн. | |
| **Зорилго 9. Газрын тосны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулна.** | | | | | | | |
| 9.1 | Газрын тосны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах, Бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан үйл ажиллагааг явуулж буй аж ахуйн нэгжид хяналт тавина. | - | Хууль болон Бүтээгдэхүүн хуваах гэрээнд нийцсэн байна. | Холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн ажилласан. | 100% | Өнөөдрийн байдлаар Тосон-Уул XIX, Тамсаг XXI, БХГ-97 талбайн газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа БХГ-ний дагуу явагдаж байгаа болно. ГТТХ-ийн 45 дугаар зүйлийн 45.1 дэх заалтад “45.1.Энэ хуулийг дагаж мөрдөхөөс өмнө буюу 1991.01.18-ны өдөр батлагдсан Газрын тосны тухай хуулийн дагуу байгуулсан гэрээнд энэ хуулийн 17.3.1, 17.3.6-17.3.11, 30.2, 30.4, 32.2, 32,3, 33.1, 33.2-т заасан төлбөр, зардал, өртөг нөхөлт, бүтээгдэхүүн хуваалтыг тухайн гэрээнд заасан хувь, хэмжээгээр зохицуулна” гэж заасан. Газрын тосны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хүрээнд 2021.09.15-21-ний өдрийн хооронд газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй Петрочайна дачин тамсаг, Доншен газрын тос (Монгол), Петроматад ХХК-уудаас санал авч нэгтгэн, газрын тосны тухай хуулийг хэрэгжүүлэхэд гарч буй | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүндрэлүүд, төрөөс гэрээлэгчид үзүүлэх дэмжлэг, хууль тогтоомжийн хүрээнд ногдуулдаг хариуцлага, хуульд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагын талаар мэдээлэл, мөн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн талаарх саналаа УУХҮЯ-нд хүргүүлсэн. Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн Тосон Уул XIX болон Тамсаг XXI гэрээт талбайн талаар 1993, 1995 онд байгуулсан БХГ-г ГТТХ-д нийцүүлэн шинэчлэх асуудлаар өнгөрсөн хугацаанд ажлын хэсгүүд байгуулагдан ажилласан байдаг. 2023 оны тухайд Засгийн газрын 2023.05.17-ны өдрийн хуралдааны 21 дүгээр тэмдэглэлд “БХГ-г дүгнэх, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэх асуудлыг судалж, санал боловсруулах арга хэмжээ авч ажиллах”-ыг Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга Д.Амарбаясгаланд даалгасан. Үүний дагуу УУХҮ-ийн сайдын 2023.05.25-ны өдрийн А/199 дугаар тушаалаар байгуулагдсан “Ажлын хэсгийг мэдээллээр хангах үүрэг бүхий” дэд ажлын хэсэг Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбайд байгуулсан БХГ-ний хэрэгжилт, хөрөнгө оруулалт, борлуулалтын орлого, бүтээгдэхүүн хуваалтын байдалд дүн шинжилгээ хийж, төслийн үр ашгийг тооцоолж, дүгнэлтээ ажлын хэсэгт танилцуулсан. | |
| 9.1.1 | Тосон-Уул XIX, Тамсаг XXI, Матад XX, 1997 оны Бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайн 2023 онд гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, төсвийн төслийг судалж, санал дүгнэлт гаргаж, батлуулах | - | Төлөвлөгөөний тоо | Төлөвлөгөө, төсвийг батлуулсан. | 2023 онд 4 төлөвлөгөө, төсвийг батлуулсан байна. | 2023 оны ажлын төлөвлөгөө, төсвийн төслийг хэлэлцэх ажлыг 2022 оны 11 дүгээр сараас 2023 оны 1 дүгээр сарын хооронд Улаанбаатар хотод зохион байгуулсан. “Петрочайна дачин тамсаг” ХХК-ийн Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбайн, “Доншен газрын тос (Монгол)” ХХК-ийн 1997 оны Бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайн, “Петро Матад” ХХК-ийн Матад XX талбайн 2023 оны ажлын төлөвлөгөө, төсвийн төслүүдийг ажлын төрөл тус бүрээр нь хэлтсийн мэргэжилтнүүд хариуцсан чиг үүргийн дагуу нарийвчлан судалж, санал, дүгнэлт гаргаж удирдлагад танилцуулсан. “Петрочайна дачин тамсаг” ХХК-тай жилийн ажлын уулзалтыг зохион байгуулж, Тосон-Уул XIX болон Тамсаг XXI талбайн 2023 оны ажлын төлөвлөгөө, төсвийг судалж санал дүгнэлтүүдийг нэгтгэн 2023.01.09-ний өдөр батлуулсан. “Доншен | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | газрын тос (Монгол)” ХХК-тай жилийн ажлын уулзалтыг зохион байгуулж, 2023 оны ажлын төлөвлөгөө, төсвийг судалж санал дүгнэлтийг нэгтгэн 2023.02.02-ны өдөр батлуулсан. Петроматад ХХК-ийн жилийн ажлын уулзалтыг 2023.05.19-ний өдөр зохион байгуулж, ажлын төлөвлөгөө, төсвийг батлуулсан. | |
| 9.1.2 | Тосон-Уул, Тамсаг, Зүүнбаян, Цагаан-Элсний газрын тосны ордын 2022 оны нөөцийн хөдөлгөөний тайланг хянах, санал дүгнэлт гаргах | - | Санал дүгнэлт гаргаж, бүртгүүлсэн байна. | Тайланг судалж, санал дүгнэлт гаргасан. | 100% | Газрын тосны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалтын дагуу “Газрын тосны баялгийн үнэлгээ, нөөцийн тооцооны тайланд тавих шаардлага” журмыг УУХҮ-ийн сайдын 2022.11.16-ны өдрийн А/287 дугаар тушаалаар баталсан. Үүний дагуу Тосон-Уул, Тамсагийн газрын тосны ордын нөөцийн тооцооны тайлангийн тодотгол, дахин тооцооллын ажлыг гүйцэтгэхээр Петрочайна дачин тамсаг ХХК-ийн 2023 оны ажлын төлөвлөгөө, төсөвт тусган төсвийг 2023.01.09-ний өдөр батлуулсан. Өнөөдрийн байдлаар судалгааны ажлууд хийгдэж байгаа ба 2023 оны жилийн уулзалтаар байгуулсан санамж бичгийн 4 дүгээр зүйлд Тосон-Уул, Тамсагийн ордын газрын тосны олборлолтыг анх батлагдсан Ордыг ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөөний тоо хэмжээнд хүргэх, нөөц батлуулсан талбайг бүрэн ашиглах, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх асуудлыг хөрөнгө оруулагчид тавьж, шийдвэрлүүлэх арга хэмжээг авч 2023.05.01-ний өдөрт багтаан Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлд хүргүүлэхээр тохиролцсон. Доншен Газрын тос (Монгол) ХХК нь Зүүнбаян, Цагаан-Элсний нөөцийн дахин тооцооллын тайлангийн төслийг Англи хэл дээр 2023.03.07-ны өдрийн 64/23 дугаар албан бичгээр ирүүлсэн. Өнөөдрийн байдлаар “Газрын тосны баялгийн үнэлгээ, нөөцийн тооцооны тайланд тавих шаардлага” журамд нийцүүлэх, монгол хэл рүү хөрвүүлэх ажлууд хийгдэж байна. 2023.04.21-ний өдрийн 1/1956, 1/1957 тоот албан бичгүүдээр Петрочайна дачин тамсаг ХХК, Доншен газрын тос Монгол ХХК-уудад Тосон-Уул, Тамсаг болон Зүүнбаян, Цагаан-Элсний ордын нөөцийн дахин тооцооллыг гүйцэтгэж, ирүүлэх талаар шаардлага хүргүүлсэн. Одоогийн байдлаар гэрээлэгч компаниуд | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нөөцийн дахин тооцооллын тайланг эцсийн байдлаар ирүүлээгүй байна. | |
| 9.1.3 | Гэрээлэгчдийн өртөг нөхөгдөх зардлын тайланг хүлээн авах, хянах шалгалтыг гүйцэтгэх. | - | Тайланг хүлээн авч, хянан шалгаж, үр дүнг нэгтгэн, дүгнэлтийг гэрээлэгчийн саналын хамт УАГ-т хүргүүлсэн байна. | Өртөг нөхөгдөх зардлыг хянаж, дүгнэлт, тайланг нэгтгэн УАГ-т хүргүүлсэн. | 100% | Петрочайна Дачин Тамсаг ХХК, Доншен газрын тос (Монгол) ХХК-д 2023.02.15-ны өдрийн 3/897, 3/898, 2022 онд хайгуулын үйл ажиллагаа явуулсан 6 гэрээлэгчдэд 2023.07.05-ны өдрийн 3/3437 дугаартай “Хяналт шалгалт хийх тухай” албан бичгийг тус тус хүргүүлсэн. Газрын тосны хайгуулын гэрээлэгчдийн 2021, 2022 оны өртөг нөхөгдөх зардлын хяналт, шалгалтыг хийж, дүгнэлтийн төслийг 2023.03.16-ны өдрийн 3/1306, 3/1307, 3/1308, 2023.03.20-ны өдрийн 3/1341, 3/1342, 2023.04.13-ны өдрийн 3/1775, 2023.11.29-ний өдрийн 3/5579, 3/5580, 3/5581, 3/5582, 3/5583 дугаартай албан бичгүүдээр гэрээлэгчдэд хүргүүлсэн. Хайгуулын 2020, 2021 оны хяналт, шалгалтын дүгнэлтийг, гэрээлэгчдийн саналын хамт 2023.03.31-ний өдрийн 1/1541, 2023.05.03-ны өдрийн 1/2184, 2023.06.21-ний өдрийн 3/3192, дугаартай албан бичгүүдээр УАГ-т хүргүүлсэн. Өртөг нөхөгдөх зардлын хяналт, шалгалтад үүссэн хоцрогдлыг арилгахаар төлөвлөгөө гарган, хяналт, шалгалтын явцын мэдээлэл, биелэлтийн хамт 2023.03.31-ний өдрийн 1/1542, 2023.06.20-ны өдрийн 1/3153 дугаар албан бичгээр УАГ-т хүргүүлсэн. Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн 2019-2021 онд өртөг нөхөгдөх болон нөхөгдсөн зардлын тайланд хяналт, шалгалт хийж, дүгнэлтийн төслийг 2023.05.31-ний өдрийн 3/2817, 2023.07.27-ны өдрийн 3/3698, 2023.09.27-ны өдрийн 3/4611 дугаартай албан бичгээр гэрээлэгчид хүргүүлсэн. Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн 2019-2021 оны өртөг нөхөгдөх болон нөхөгдсөн зардлын тайланд гүйцэтгэсэн хяналт шалгалтын тайланг 2023 оны 06 дугаар сарын 3/3246, 2023 оны 07 дугаар сарын 1/3726, 2023 оны 09 дүгээр сарын 1/4658 дугаар албан бичгүүдээр УАГ-т хүргүүлсэн. | 90% |
| **Зорилго 10. Газрын тос, уламжлалт бус газрын тосны ордуудыг ашиглалтад шилжүүлэх, ордын ашиглалтыг эрчимжүүлэн, олборлолтыг боломжит хэмжээгээр нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлэх, Бүтээгдэхүүн хуваах гэрээний хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулна.** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 10.1 | Газрын тосны ордын ашиглалтыг эрчимжүүлж, олборлолтыг боломжит хэмжээгээр нэмэгдүүлнэ. | - | Олборлолт, экспортын тоо хэмжээнд хяналт тавьж ажилласан байна. | 2022 онд 2.5 сая баррель буюу 347.9 мянган газрын тос олборлож, 2.6 сая баррель буюу 353.2 мянган газрын тос экспортолсон. | Олборлолт, экспортын тоо хэмжээнд хяналт тавьж, бүртгэл хөтөлсөн байна. | Монгол Улсын хэмжээнд 2023 онд нийт 6.5 сая баррель буюу 883.8 мянган тонн түүхий тос олборлож, экспортлохоос 2023.12.01-ний өдрийн байдлаар 4.5 сая баррель буюу 611.1 мянган тонн түүхий тос олборлож, 4.4 сая баррель буюу 593.7 мянган тонн түүхий тос экспортолсон. Олборлолтын гүйцэтгэл 69.2 хувьтай, харин экспортын төлөвлөгөөний гүйцэтгэл 67.7 хувьтай байна. Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу газрын тосны олборлолт, ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй 3 талбайгаас 2023 онд нийт 6.5 сая баррель буюу 883.8 мянган тонн газрын тос олборлож, Улсын төсөвт 424.9 тэрбум төгрөг төвлөрүүлэх төлөвлөгөөтэй байснаас 2023.12.01-ний өдрийн байдлаар гүйцэтгэл 281.4 тэрбум төгрөг буюу 66.8 хувь байна. Орон нутгийн эсэргүүцэл, халдварт өвчин, технологийн ажлуудыг төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэж чадахгүй байгаа байдал, цахилгаан эрчим хүчний хязгаарлагдмал байдал зэрэг хүчин зүйлсээс хамаарч газрын тосны экспортын борлуулалтын хэмжээнд нөлөөлж байна. Газрын тосны борлуулалтын орлогын 92 хувийг бүрдүүлэгч “Петрочайна дачин тамсаг” ХХК нь Газрын тосны тухай хууль болон бүтээгдэхүүн хуваах гэрээ хоорондын зөрчилдөөн, татварын акт, төрийн бус байгууллагуудын эсэргүүцэл зэргээс хамаарч хөрөнгө оруулалтаа бууруулж байна. Үүнтэй холбогдуулан газрын тосны олборлолтыг нэмэгдүүлэх технологийн ажлууд бага хийгдэж, олборлолт багасаж байна. Газрын тосны салбарын эрх зүйн орчныг тогтвортой байлгах, газрын тосны тухай хууль болон бүтээгдэхүүн хуваах гэрээний зөрчилдөөний асуудлыг шийдвэрлүүлэх зорилгоор Үндэсний аюулгүй байдлын алба, Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газар зэрэгт тус тус хандаж, олборлолтын нөхцөл байдал, Гэрээлэгч нарын байр суурийн талаар мэдээлэл хүргүүлж, зөвлөмж авахаар албан бичиг хүргүүлсэн. | 90% |
| 10.1.1 | Олборлож буй тосны тоо хэмжээнд газар дээр нь | - | Хяналт тавьж, Баасан | 2022 онд 2.5 сая баррель | Олборлолтын тоо хэмжээнд | Газрын тосны ашиглалтын Тосон-Уул XIX, Тамсаг XXI, 1997 оны БХГ-т талбайд мэргэжилтнүүд давхардсан тоогоор нийт 630 хоног албан томилолтоор газар дээр | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байнгын хяналт тавьж ажиллах | | гараг бүр удирдлагыг мэдээллээр хангасан байна. | буюу 347.9 мянган газрын тос олборлосон. | хяналт тавьж, бүртгэл хөтөлсөн байна. | нь цооногуудын олборлолт, шавхалт, ус шахалтын өдөр тутмын мэдээн дээр үндэслэн байнгын хяналт тавьж, ажиллаж байна. БХГ-97 талбайгаас 2023 онд 384,384 баррель буюу 53,760 тонн газрын тос олборлож, экспортлох төлөвлөгөөтэй байгаагаас 2023.12.01-ний өдрийн байдлаар 380,875 баррель буюу 53,269 тонн газрын тос олборлосон, гүйцэтгэл 99% байна. Тосон-Уул XIX талбайгаас 2023 онд 2,725,484 баррель буюу 362,432 тонн газрын тос олборлож, экспортлох төлөвлөгөөтэй байгаагаас 2023.12.01-ний байдлаар олборлолтын тоног төхөөрөмж суурилуулсан 207 цооногоос 1,786,366 баррель, задгайгаар буюу цооног шавхалтаар 216,754 баррель, нийт 2,003,119 баррель буюу 265,776 тонн газрын тос олборлосон, гүйцэтгэл 73% байна. Тамсаг XXI талбайгаас 2023 онд 2,765,272 баррель буюу 381,417 тонн газрын тос олборлож, экспортлох төлөвлөгөөтэй байгаагаас 2023.12.01-ний өдрийн байдлаар олборлолтын тоног төхөөрөмж суурилуулсан 260 цооногоос 1,959,823 баррель, задгайгаар буюу цооног шавхалтаар 156,938 баррель, нийт 2,116,760 баррель буюу 292,039 тонн газрын тос олборлосон, гүйцэтгэл 76% байна. Олборлолтыг нэмэгдүүлэх талаар гэрээлэгч компаниудтай хэд хэдэн удаа уулзалт зохион байгуулж ажилласан. Олборлолтыг нэмэгдүүлэх болон төлөвлөгөөний дагуу явуулахад гарч буй хүндрэлд: Бүтээгдэхүүн хуваах гэрээг Газрын тосны тухай хуулийн дагуу шинэ загварт оруулан шинэчлэх мөн нийгмийн даатгал, татварын маргаантай асуудлуудаас болж гэрээлэгчийн дансыг битүүмжлэх, эрчим хүчний хомсдол, гэрээлэгч нь хөрөнгө оруулалтынхаа хэмжээг багасгасан гэх мэт. | |
| 10.1.2 | Экспортолж буй тосны тоо хэмжээ, чанарын шинжилгээнд газар дээр нь байнгын хяналт тавьж ажиллах | - | Экспортын тосны усны агууламж 0.5 хувиас | 2022 онд 2.6 сая баррель буюу 353.2 мянган газрын тос | Экспортын тоо хэмжээнд хяналт тавьж, бүртгэл | Газрын тосны ашиглалтын Тосон-Уул XIX, Тамсаг XXI, 1997 оны БХГ-т талбайд мэргэжилтнүүд давхардсан тоогоор нийт 630 хоног албан томилолтоор ажилласан. Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбайгаас экспортын ачилт хийж буй цэгт хөндлөнгийн хяналтын эрх бүхий Амбер ХХК-аар газрын тосны тоо хэмжээ, чанарын шинжилгээний хэмжилтийг хийлгэн, ГЕГ-ын орон нутаг | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хэтрэхгүй байна. | экспортолсон. | хөтөлсөн байна. | дахь салбар болон ГТАХ-ийн мэргэжилтнүүд экспортолж буй газрын тосны чанарын шинжилгээ, ачилт, буулгалтын тоо хэмжээнд хяналт тавьж, бүртгэл хөтлөн газар дээр нь тогтмол хяналт тавьж ажиллаж байна. БХГ-97 талбайн Танк фармд байрлах газрын тос хадгалах савнаас шахуурга ашиглан 21 вагонцистернд ачилтыг гүйцэтгэдэг. Ачилт эхлэхээс өмнө хөндлөнгийн хяналтын эрх бүхий Амбер ХХК вагонцистернд хэмжилт хийж, ачсан тосны хэмжээг тогтоож, ГЕГ орон нутаг дахь салбар, ГТАХ-ийн мэргэжилтэн экспортолж буй газрын тосны чанарын шинжилгээ, ачилт, буулгалтын тоо хэмжээнд хяналт тавьж, бүртгэл хөтлөн газар дээр нь тогтмол хяналт тавьж ажиллаж байна. Мөн тээвэр зуучийн мэргэжилтэн, Зүүнбаян дахь төмөр замын өртөөний ажилтан, Доншен газрын тос (Монгол) ХХК төлөөлөгч нар газрын тосны экспортын үйл ажиллагаанд хамтран ажилладаг. БХГ-97 талбайгаас 2023.12.01-ний өдрийн байдлаар нийт 392,573 баррель буюу 55,121 тонн газрын тос экспортолж, төлөвлөгөөний гүйцэтгэл 102.5 хувьтай байна. Тосон-Уул XIX талбайгаас 2023 онд 2,725,484 баррель буюу 362,432 тонн газрын тос олборлож, экспортлох төлөвлөгөөтэй байгаагаас 2023.12.01-ний өдрийн байдлаар нийт 1,889,904 баррель буюу 250,830 тонн газрын тосыг БНХАУ руу экспортолж, гүйцэтгэл 69 хувьтай байна. Тамсаг XXI талбайгаас 2023 онд 2,765,272 баррель буюу 381,417 тонн газрын тос олборлож, экспортлох төлөвлөгөөтэй байгаагаас 2023.12.01-ний өдрийн байдлаар нийт 2,084,937 баррель буюу 287,782 тонн газрын тосыг БНХАУ руу экспортолсон ба гүйцэтгэл 75 хувьтай байна. | |
| **Зорилго 11. Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн тогтвортой байдлыг хангах, К-5 (Евро-5) стандартын шатахууны импорт, хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна.** | | | | | | | |
| 11.1 | Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн тогтвортой байдлыг хангах ажлыг зохион байгуулна. | - | Тоо хэмжээ | 2022 онд 1,9 сая тонн газрын тосны бүтээгдэхүүн | 1.9 сая тонн 27% | Улсын хэмжээнд 2023.11.30-ны өдрийн байдлаар нийт 2.1 сая тонн газрын тосны бүтээгдэхүүн импортлон хэрэглэснээс 1.9 сая тонн нь бүх төрлийн шатахуун байна. Үүнээс 243 мянган тонн нь Евро-5 стандартын шатахуун буюу нийт шатахууны 14 хувь байна. Манай улсын газрын тосны бүтээгдэхүүний гол нийлүүлэгч | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | импортолсон. К-5 (Евро-5) шатахууны хэмжээ 23%-д хүрсэн. | | ОХУ-ын дотоод зах зээлийн нөхцөл байдалтай холбоотойгоор тус улсын Засгийн газраас 2023.09.22-ны өдрөөс хэрэгжүүлсэн экспортын шатахууныг хориглох шийдвэр тодорхой хэмжээнд нөлөөлсөн. - БНХАУ-аас 2023 онд нийт 34 мянган тонн Евро-5 стандартын дизель түлш импортолж, тус стандартын шатахууны хэмжээг тодорхой хувиар нэмэгдүүлсэн хэдий ч зорилтот түвшинд хүргэхэд хил үнэ, төлбөрийн хатуу нөхцөл, гадаад нийлүүлэгчээс гаргаж буй гэнэтийн шийдвэр, дотоодын төмөр замын вагоны дутагдал, тус стандартын шатахууныг хадгалах тусгай зориулалтын агуулах, савны хүрэлцээ зэрэг олон хүчин зүйл нөлөөлсөн. | |
| 11.1.1 | Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн тогтвортой байдлыг хангах хүрээнд нийлүүлэгч талуудтай харилцах, хамтын ажиллагааг хөгжүүлэх, жил бүрийн уулзалтад оролцох, импортын бусад эх үүсвэрийг нэмэгдүүлэх боломжийг судлах, санал боловсруулах | Албан томилолтын зардал | Нийлүүлэгч талтай хийх уулзалтад оролцох, хэлэлцэх асуудалд санал боловсруулсан байна. | - | 100% | - Газрын тосны бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах хүрээнд манай улсын газрын тосны бүтээгдэхүүний гол бэлтгэн нийлүүлэгч ОХУ-ын Роснефть компанитай 2023 онд нийт 3 удаа уулзалт, хэлэлцээр хийсэн бөгөөд түүнд хэлэлцэгдэх саналыг боловсруулан, УУХҮЯ-нд хүргүүлсэн. Үүний үр дүнд энэ онд Аи-92 автобензиний хангамж, үнэ тогтвортой байсан. Дизель түлшний хувьд ОХУ-ын дотоод зах зээл дээр шатахууны хэрэглээ өссөн, дайны нөхцөл байдлаас шалтгаалан тус улсын Засгийн газраас 2023.09.22-ны өдрийн тогтоолоор газрын тосны бүтээгдэхүүний экспортыг тодорхойгүй хугацаагаар хориглох шийдвэр гарсантай холбогдуулан 9,10 дугаар сард импорт буурсан. Гэсэн хэдий ч МУ-ын ЗГ-аас холбогдох арга хэмжээ авч ажилласны үр дүнд 2023.10.06-ны өдрөөс эхлэн ОХУ-аас Наушки-Сүхбаатар төмөр замын боомтоор манай улсад газрын тосны бүтээгдэхүүн нийлүүлэх экспортын үйл ажиллагааг сэргээсэн. - Импортын эх үүсвэрийг нэмэгдүүлэх хүрээнд БНХАУ-тай тогтмол харилцаатай ажиллаж, тус улсаас 2023 оны 10 дугаар сард 4680 тонн Аи-92 автобензин хүлээн авсан бол 12 дугаар сард 30 мянган тонн дизель түлш авах захиалгыг 11 дүгээр сард баталгаажуулж, эхний ачилтууд /44 вагон дизель түлш/ Монгол улсад орж ирсэн. Цаашид тус улсаас түлш, | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шатахуун импортлох хүсэлтэй "Содон ойл" ХХК, "Синчи ойл" ХХК, "Хөрс автосервис" ХХК, "Петрохаан" ХХК зэрэг компаниудын хүсэлтийг "Петрочайна Интернэшнл" ХХК-д дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах хүсэлтийг уламжилсан. - Мөн импортын эх үүсвэрийг нэмэгдүүлэх хүрээнд өмнөд бүсийн Гашуунсухайт, Шивээхүрэнгийн боомтод шилжүүлэн ачих байгууламж барих төслийн ажлыг энэ онд эхлүүлсэн бөгөөд гүйцэтгэл хугацаандаа явагдсан. | |
| 11.1.2 | К-5 (Евро-5) стандартын шатахууны импорт, хэрэглээг нэмэгдүүлэх, нийлүүлэлтийг дэмжих санал боловсруулах, дэмжлэг үзүүлэх. | - | К5 (Евро 5)-ын хэмжээ, хувийг нэмэгдүүлсэн байна. | 23% | 35% | Улсын хэмжээнд 2023.11.30-ны өдрийн байдлаар нийт 2.1 сая тонн газрын тосны бүтээгдэхүүн импортлон хэрэглэснээс 1.9 сая тонн нь бүх төрлийн шатахуун байна. Үүнээс 243 мянган тонн нь Евро-5 стандартын шатахуун буюу нийт шатахууны 14 хувь байна. Энэ нь манай улсын газрын тосны бүтээгдэхүүний гол нийлүүлэгч ОХУ-ын дотоод зах зээлийн нөхцөл байдалтай холбоотойгоор тус улсын Засгийн газраас 2023.09.22-ны өдрөөс хэрэгжүүлсэн экспортын шатахууныг хориглох шийдвэр гарсантай холбоотой байсан. - БНХАУ-аас 2023 онд нийт 34 мянган тонн Евро-5 стандартын дизель түлш импортолж, тус стандартын шатахууны хэмжээг тодорхой хувиар нэмэгдүүлсэн хэдий ч зорилтот түвшинд хүргэхэд хил үнэ, төлбөрийн хатуу нөхцөл, гадаад нийлүүлэгчээс гаргаж буй гэнэтийн шийдвэр, дотоодын төмөр замын вагоны дутагдал, тус стандартын шатахууныг хадгалах тусгай зориулалтын агуулах, савны хүрэлцээ зэрэг олон хүчин зүйл нөлөөлсөн. | 50% |
| 11.1.3 | Баруун бүсийн шатахууны хэрэглээний тодорхой хувийг хангах зорилгоор Ховд аймагт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар бага оврын газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэр байгуулахад дэмжлэг үзүүлэх | Албан томилолтын зардал | ТЭЗҮ болон БОНБНҮ | Байгаль орчны ерөнхий болон нарийвчилсан үнэлгээний тайланг мэргэжлийн | ТЭЗҮ-г боловсруулж, батлуулахад дэмжлэг үзүүлсэн байна. 20% | - Баруун бүсийн шатахууны хэрэглээний тодорхой хувийг хангах зорилгоор Ховд аймагт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар бага оврын газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэр байгуулах санаачилга гаргасан газрын тосны бүтээгдэхүүний үйлдврэлэлийн тусгай зөвшөөрөлтэй "Трансгейт интэрнэшнл" ХХК нь Ховд аймгийн Жаргалант сумын нутагт үйлдвэрийн зориулалтаар 6.0 га газар эзэмших зөвшөөрөл авч, тус газарт баригдах үйлдвэрийн агуулахын зураг төслийг боловсруулж, Ховд аймгийн Мэргэжлийн хяналтын газар | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | байгууллагаар гүйцэтгүүлэн, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Зөвлөлөөр хэлэлцүүлсэн. | | /хуучин нэрээр/, ОБЕГ, БХБЯ-ны Барилгын хөгжлийн төвөөр тус тус батлуулсан. Мөн тус төслийн гол ажил болох Байгаль орчинд нөлөөлөх байдлын Ерөнхий болон Нарийвчилсан үнэлгээний тайланг боловсруулахад манай байгууллагаас холбогдох мэргэжлийн зөвлөмж, саналыг өгсөн бөгөөд БОАЖЯ-ны Мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэн, батлуулсан. - Дараагийн гол ажил болох үйлдвэрлэлийн ТЭЗҮ-ийг боловсруулахад компанийн зүгээс гадаад нөхцөл байдлаас шалтгаалан зарим шаардлагатай тодотголыг хийж байгаа бөгөөд ялангуяа үйлдвэрийн техник технологитой холбоотой мэргэжлийн зөвлөмжийг манай байгууллагаас хүргүүлж, боловсруулалтад дэмжлэг үзүүлсэн. | |
| 11.1.4 | “Агаар орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр”-ийн 4.3.2 дахь заалтын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах, биелэлтэд хяналт тавих. | - | Хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулсан байна. | Хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулсан. | 100% | - Тус хөтөлбөрт тусгагдсан Евро-5 стандартын шатахууны импорт, хэрэглээг нэмэгдүүлэх хүрээнд тухайн бүтээгдэхүүний импорт, хэрэглээг дэмжсэн эрх зүй, татварын орчин бүрдүүлэх шаардлага тулгарсан. 2023 онд Засгийн газраас автобензинимй ГАТ-ыг, мөн дизель түлшний ОАТ-ын хувь хэмжээг тус тус 0 хувиар тогтоох арга хэмжээ авсан бөгөөд тус тогтоолын хэрэгжих хугацаа дууссаны дараа Евро-5 стандартын шатахууны хэмжээг нэмэгдүүлэхэд ГАТ, ОАТ-ын хувь хэмжээг энгийн стандартын шатахуунаас ялгаж тогтоох саналыг УУХҮЯ-ны холбогдох нэгжид танилцуулсан. - Манай улс импортын 2 эх үүсвэртэй, үүний нэг нь БНХАУ бөгөөд 2023 онд тус улсаас Евро-5 стандартын шатахууны хэмжээг нэмэгдүүлэх хүрээнд нийт 34 мянган тонн Евро-5 дизель түлш импортолсон ба цаашид урт хугацаанд хамтран ажиллах хүсэлтэй бүх төрлийн шатахууны импортын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн хүсэлтийг уламжилж, дэмжлэг үзүүлэн ажилласан. Улсын хэмжээнд 2023.11.30-ны өдрийн байдлаар 2.1 сая тонн газрын тосны бүтээгдэхүүн импортлон хэрэглэснээс 1.9 сая тонн нь бүх төрлийн шатахуун байна. Үүнээс 243 мянган тонн нь Евро-5 стандартын шатахуун буюу нийт шатахууны 14 хувь байна. | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилго 12. Уул уурхайн салбар болон Ашигт малтмал, газрын тосны газрын үйл ажиллагааны статистик мэдээг нэгтгэн боловсруулна.** | | | | | | | |
| 12.1 | Ашигт малтмал, газрын тосны газрын үйл ажиллагаатай холбоотой статистик мэдээний тайланг сар бүр боловсруулан гаргаж, хэрэглэгчдийг мэдээллээр хангана. | - | Сард 1 удаа | 12 | 12 | Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2021.04.05-ны өдрийн А/63 дугаар тушаалаар батлагдсан “Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд Ашигт малтмал, газрын тосны газар болон Үндэсний геологийн албанаас мэдээ, тайлан ирүүлэх журам”-ын дагуу Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтэс, Ашигт малтмалын хайгуулын хэлтэс, Газрын тосны хайгуулын хэлтэс, Уул уурхайн хэлтэс, Уул уурхай, газрын тосны төв лаборатори, Газрын тосны ашиглалтын хэлтэс, Газрын тосны бүтээгдэхүүний хэлтэс, Санхүү хөрөнгө оруулалтын хэлтэс, Төрийн захиргааны удирдлагын газар, Хууль эрх зүйн хэлтсээс холбогдох 10 төрлийн 7 хоногийн мэдээг 48 удаа, сарын 28 төрлийн мэдээг 12 удааг хянаж, Уул уурхай хүнд үйлдвэрийн яамны холбогдох албан хаагчдад цахимаар хүргүүлсэн. | 100% |
| 12.1.1 | Статистик мэдээний эмхэтгэлийг удирдлага болон холбогдох төрийн байгууллагуудад түгээх, агентлагийн вэб хуудсанд англи, монгол хэлээр байршуулах | - | Сард 1 удаа | 12 | 12 | Эрдэс баялгийн статистик мэдээг 2022 оны 12 дугаар сар, 2023 оны 1-11 дүгээр сарын мэдээг Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтэс, Ашигт малтмалын хайгуулын хэлтэс, Газрын тосны хайгуулын хэлтэс, Уул уурхайн хэлтэс, Газрын тосны ашиглалтын хэлтэс, Газрын тосны бүтээгдэхүүний хэлтэс, Төрийн захиргааны удирдлагын газар, Санхүү хөрөнгө оруулалтын хэлтсээс хүлээн авч хянан, нийт 12 бүлгийн 50 төрлийн хүснэгт, график бүхий 31 хуудас статистик мэдээний эмхэтгэлийг нийт 12 удаа бэлтгэж, холбогдох төрийн байгууллагуудад түгээж, байгууллагын цахим хуудсанд Монгол, Англи хэлээр нийтэлсэн. | 100% |
| 12.1.2 | Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2021 оны 4 дүгээр сарын 5-ны өдрийн А/63 тоот тушаалаар батлагдсан “Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд Ашигт малтмал, газрын тосны газар болон Үндэсний геологийн | - | Сард 1 удаа | 12 | 12 | Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2021.04.05-ны өдрийн А/63 дугаар тушаалаар батлагдсан “Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд Ашигт малтмал, газрын тосны газар болон Үндэсний геологийн албанаас мэдээ, тайлан ирүүлэх журам”-ын дагуу Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтэс, Ашигт малтмалын хайгуулын хэлтэс, Газрын тосны хайгуулын хэлтэс, Уул уурхайн хэлтэс, Уул уурхай, газрын тосны төв лаборатори, Газрын тосны ашиглалтын хэлтэс, Газрын | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | албанаас мэдээ, тайлан ирүүлэх журам”-ын дагуу хэлтсүүдээс мэдээ, тайлан хүлээн авч нэгтгэн, холбогдох газруудад хүргэх | | | | | тосны бүтээгдэхүүний хэлтэс, Санхүү хөрөнгө оруулалтын хэлтэс, Төрийн захиргааны удирдлагын газар, Хууль эрх зүйн хэлтсээс холбогдох 10 төрлийн 7 хоногийн мэдээг 48 удаа, сарын 28 төрлийн мэдээг 12 удааг хянаж, Уул уурхай хүнд үйлдвэрийн яамны холбогдох албан хаагчдад цахимаар хүргүүлсэн. | |
| **Зорилго 13. Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт зөвлөмж өгнө.** | | | | | | | |
| 13.1 | Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын хүрээнд: Хууль тогтоомж, бодлогын баримт бичгүүдэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд хүргүүлнэ. | - | Биелэлтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт зөвлөмж боловсруулан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд хүргүүлсэн байна. | Хяналт шинжилгээ, үнэлгээг хийж, дүгнэлт зөвлөмжийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд хүргүүлсэн. | 100% | Ашигт малтмал, газрын тосны газарт хамаарах хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг 2023 оны эхний хагас жилийн биелэлтийг газар, хэлтсүүдээс “Салбарын Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим сан”-д тайлагнуулж, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, АМГТГ-ын даргын 2023 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 1/3478 тоот албан бичгээр УУХҮЯ-нд хүргүүлсэн. Ашигт малтмал, газрын тосны газарт хамаарах “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн хэрэгжилт нь 2023 эхний хагас жилийн байдлаар 65.8 хувьтай үнэлэгдсэн. Үнэлгээгээр удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан 1 /100 хувь/, хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай 7 /70-99 хувь/, үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай 2 /31-69 хувь/, удирдлага зохион байгуулалт хангалтгүй 2 /0-30 хувь/ гэж үнэлж, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд 2023 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 1/3302 тоот албан бичгээр хүргүүлсэн. “Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө”-ний Ашигт малтмал, газрын тосны газрын чиг үүрэгт хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд 2023 оны эхний хагас жилийн байдлаар Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, удирдлагад танилцуулж, тайланг Уул уурхай, хүнд үйлдвэрийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | яаманд 2023 оны 06 дүгээр сарын 14-ний өдрийн 1/3058 дугаар албан бичгээр хүргүүлсэн. | |
| 13.1.1 | Төрийн захиргааны удирдлагын хэлтсээс нэгтгэн ирүүлсэн Ашигт малтмал, газрын тосны газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, хууль тогтоомж, Улсын Их Хурал, Монгол улсын Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилт, Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл болон бусад бодлогын баримт бичгийн биелэлтэд хагас жил, жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт, санал зөвлөмж боловсруулах | - | Биелэлтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт зөвлөмж боловсруулан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд хүргүүлсэн байна. | Хяналт шинжилгээ, үнэлгээг хийж, дүгнэлт зөвлөмжийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд хүргүүлсэн. | 100% | Ашигт малтмал, газрын тосны газарт хамаарах хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг 2023 оны эхний хагас жилийн биелэлтийг газар, хэлтсүүдээс “Салбарын Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим сан”-д тайлагнуулж, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, АМГТГ-ын даргын 2023 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 1/3478 тоот албан бичгээр УУХҮЯ-нд хүргүүлсэн. Ашигт малтмал, газрын тосны газарт хамаарах “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн хэрэгжилт нь 2023 эхний хагас жилийн байдлаар 65.8 хувьтай үнэлэгдсэн. Үнэлгээгээр удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан 1 /100 хувь/, хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай 7 /70-99 хувь/, үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай 2 /31-69 хувь/, удирдлага зохион байгуулалт хангалтгүй 2 /0-30 хувь/ гэж үнэлж, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд 2023 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 1/3302 тоот албан бичгээр хүргүүлсэн. “Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө”-ний Ашигт малтмал, газрын тосны газрын чиг үүрэгт хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд 2023 оны эхний хагас жилийн байдлаар Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, удирдлагад танилцуулж, тайланг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд 2023 оны 06 дүгээр сарын 14-ний өдрийн 1/3058 дугаар албан бичгээр хүргүүлсэн. | 100% |
| **Зорилго 14. Агентлагийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийнэ.** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 14.1 | Агентлагийн 2022 оны батлагдсан төсөв болон гүйцэтгэл, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан дотоод аудит хийнэ. | - | Аудитын үйл ажиллагааны дүгнэлт, санал, зөвлөмж гарган зөрчлийг арилгуулах арга хэмжээ авсан байна. | Холбогдох хууль тогтоомж, дүрэм журамд нийцүүлэн ажилласан. | 100% | Ашигт малтмал газрын тосны газрын 2022 оны Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын багцын худалдан авах ажиллагаагаар "урсгал төсөв", "төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг дэмжих хөрөнгө" гэсэн 2 эх үүсвэрээс нийт 17 нэр төрлийн 924,970,400 төгрөгийн өртөг бүхий бараа, ажил, үйлчилгээний ерөнхий төлөвлөгөөг батлуулж, худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулсан байдалд дотоод аудит хийж санал дүгнэлт, зөвлөмж боловсруулж удирдлагад танилцуулсан. | 100% |
| 14.1.1 | Ашигт малтмал, газрын тосны газрын 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан дотоод аудит хийх | - | Аудитын үйл ажиллагааны дүгнэлт, санал, зөвлөмж гарган зөрчлийг арилгуулах арга хэмжээ авсан байна. | Дотоод аудитыг хийж, дүгнэлт зөвлөмжийг нэгжийн даргад танилцуулсан. | 100% | Ашигт малтмал газрын тосны газрын 2022 оны Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын багцын худалдан авах ажиллагаагаар "урсгал төсөв", "төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг дэмжих хөрөнгө" гэсэн 2 эх үүсвэрээс нийт 17 нэр төрлийн 924,970,400 төгрөгийн өртөг бүхий бараа, ажил, үйлчилгээний ерөнхий төлөвлөгөөг батлуулж, худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулсан байдалд дотоод аудит хийж санал дүгнэлт, зөвлөмж боловсруулж удирдлагад танилцуулсан. | 100% |
| 14.1.2 | Шилэн дансны тухай, Мэдээллийн ил тод байдлын тухай хуулиудын холбогдох заалтын дагуу байгууллагын шилэн дансны хөтлөлтөд хяналт тавьж ажиллах | - | Улирал бүр холбогдох мэдээллийг байршуулсан эсэхэд хяналт | Холбогдох мэдээллийг байршуулсан эсэхэд сар бүр хяналт тавьсан. | 100% | "Шилэн дансны тухай" хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай" журмыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд, АМГТГ-ын даргын тушаалаар ажлын хэсэг байгуулан ажиллаж мэдээллийг үнэн зөв, бүрэн мэдээлж байгаа эсэхэд тогтмол хяналт тавьж ажилласан. Шилэн дансны цахим хуудасны "Бусад" цэсэд 2022 оны байдлаар "Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль"-ийн 8 дугаар зүйлд заасан | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | тавьсан байна. | | | мэдээллийг тухай бүр оруулаагүй, хугацаа хоцроож мэдээлсэн байдалд хяналт тавьж, мэдээллийг бүрэн гүйцэт болгуулж, шилэн дансны цахим хуудсанд байршуулсан. Шилэн дансны 2022 он, 2023 оны 1, 2, 3 дугаар улирлын тайланг гаргаж, хуулийн хугацаанд УУХҮЯ-ны ХШҮДАГ-т хүргүүлсэн. "Шилэн данс"-ны хөтлөлтөд 2023 оны эхний хагас жилийн байдлаар аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулж ТЗУГ-т хүргүүлэн, хэрэгжилтийг зохион байгуулж ажилласан. | |
| **Зорилго 15. Агаар орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн 4.3.2 дахь заалтад “Евро-5” стандартад нийцсэн чанарын шаардлага хангасан шатахууны чанарын хяналтын тоголцоог сайжруулах” гэж заасныг хэрэгжүүлэх зорилгоор газрын тосны бүтээгдэхүүнд чанарын шинжилгээ хийх, сайжруулсан түлшний физик химийн шинж чанар, үзүүлэлтүүдийг тодорхойлж, шинжилгээг хийнэ.** | | | | | | | |
| 15.1 | Хяналт шалгалтын явцад шинжилгээний ажлыг тогтмол шуурхай гүйцэтгэнэ. | - | Ирүүлсэн дээжийн тоо | Дээжид шинжилгээ хийсэн. | 100% | Улаанбаатар хотод газрын тосны бүтээгдэхүүний бөөний болон жижиглэн борлуулалтын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн агуулах, шатахуун түгээх станцуудын хяналт шалгалт болон Нийслэлийн агаар, орчны бохирдолтой тэмцэх газар (https://aprd.ub.gov.mn) ,ЭХЯ болон Таван толгой түлш ХХК (https://ttt.mn)-ийн Сайжруулсан хатуу түлшний чанарын шинжилгээг стандартын дагуу хийж, тайланг захиалагчид хүргүүлж ажилласан. | 90% |
| 15.1.1 | Зах зээлд худалдан борлуулагдаж байгаа газрын тосны бүтээгдэхүүнд чанарын шинжилгээг хийх | Дээж цуглуулах болон шинжилгээ хийх зардал. | Ирүүлсэн дээжийн тоо | Дээжид шинжилгээ хийсэн. | 100% | Засгийн газрын 2022.10.19-ний өдрийн 378 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2023.01.09-ний өдөр баталсан Улаанбаатар хотод газрын тосны бүтээгдэхүүний бөөний болон жижиглэн борлуулалтын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн компанийн нөөцийн бүрдүүлэлтэд хяналт хийх, агуулах, шатахуун түгээх станцуудаар борлуулж буй шатахууны чанар, стандартын байдалд хяналт, шалгалт хийх ажлын төлөвлөгөөний дагуу авто бензин, дизель түлшний дээжүүдийг түүвэрлэн авсан. Үүнд: - авто бензиний /Аи-92/ -51 ш - авто бензиний Аи-95 /к-5/ -12 ш - дизель түлшний /к-2-5/ -78 ш нийт 168 дээжид MNS 6861:2020, MNS 0216:2017, MNS 0217:2017, ASTM D5453-09 стандартын дагуу шинжилгээг хийж гүйцэтгэн үр дүнг боловсруулан тайлагнасан. | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 15.1.2 | Сайжруулсан хатуу түлшний физик химийн шинж чанарын шинжилгээг хийх | Тоног төхөө рөмж, сэлбэг хэрэгсэл, урвалж бодисын зардал | Ирүүлсэн дээжийн тоо | Дээжид шинжилгээ хийсэн. | 100% | Сайжруулсан хатуу түлшний нийт 205 дээжид - MNS GB/T 474, Нүүрсний дээж бэлтгэх арга - MNS GB/T 212, Нүүрсний техникийн шинжилгээний арга - MNS 0655, Хүрэн, чулуун нүүрс, антрацит ба шатах занар, Чийгийг тодорхойлох арга - MNS ISO 1928, Хатуу эрдэс түлшний илчлэгийн нийт утгыг бортогон калориметрийн аргаар тодорхойлох ба илчлэгийн цэвэр утгыг тооцоолох арга - MNS ASTM D 4239, Нүүрс ба коксын дээжид өндөр темдературын хоолойт зуух ашиглан хүхрийн хэмжээг тодорхойлох арга - MNS ISO 1170, Нүүрс ба кокс - янз бүрийн төлөвтэй шинжилгээний үр дүнг шилжүүлэн тооцоолох - MNS 5679 : 2022 Сайжруулсан хатуу түлш. Техникийн шаардлага стандартын дагуу чанарын шинжилгээг хийж үр дүнг боловсруулан, сорилтын тайланг захиалагч байгууллагад хүргүүлж ажилласан. Үүнд: -Нийслэлийн агаар, орчны бохирдолтой тэмцэх газар (https://aprd.ub.gov.mn) - 29 дээж, - Эрчим хүчний яам - 5 дээж, -БОАЖЯ-11 дээж, - Таван толгой түлш ХХК (https://ttt.mn)-148 дээж, - Бусад ААН-ын 12 дээж. | 100% |

**ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР:**

**УИХ-**Улсын их хурал
**УУХҮЯ –** Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
**УУХҮ-ийн сайд –** Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд
**БОАЖЯ-**Байгаль орчин, аялал жуулчлалын яам
**СЯ-**Сангийн яам
**АМГТГ-** Ашигт малтмал, газрын тосны газар
**ЭБМЗ-** Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл
**ТЭЗҮ-** Техник, эдийн засгийн үндэслэл
**ТЗУГ-** Төрийн захиргааны удирдлагын газар
**ХАГ-** Хайгуул, ашиглалтын газар
**ГТБГ-** Газрын тос,бүтээгдэхүүний газар
**АМХХ-** Ашигт малтмалын хайгуулын хэлтэс
**УУХ-** Уул уурхайн хэлтэс
**СХОХ**- Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс
**КХ- К**адастрын хэлтэс

**ХЭЗХ-** Хууль, эрхзүйн хэлтэс
**ГТХХ-** Газрын тосны хайгуулын хэлтэс
**ГТАХ-** Газрын тосны ашиглалтын хэлтэс
**ГТБХ-** Газрын тосны бүтээгдэхүүний хэлтэс
**ХШҮДАХ-** Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтэс
**УУГТТЛ-** Уул уурхай, газрын тосны төв лаборатори
**ЗГҮАХ-** Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр
**ЗГҮАХХАХТ-** Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө
**АМТХ-** Ашигт малтмалын тухай хууль
**МУХТЖҮЧ-** Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл
**БХГ-**Бүтээгдэхүүн хуваах гэрээ
**ТӨҮГ-** Төрийн өмчит үйлдвэрийн газар
**БОМТ-**Байгаль орчны менежментийн төлөвлөгөө
**ХБНГУ**- Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
**БНХАУ-** Бүгд Найрамдах Хятад Ард Улс
**ОХУ-** Оросын Холбооны Улс